

## УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БЭЛТГЭЛ АЖИЛ БҮРЭН ХАНГАГДЛАА



АНУ-ын Мянганы сорилтын корпорацын 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг байгуулж ашиглалтад оруулах, мөн Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах төслийг хэрэгжүүлэхээр болсон. Монгол Улсын Засгийн газраас хүлээсэн нөхцөл шаардлагыг бүрэн хангасан тул 2021 оны 3 дугаар сарын 31-нд Компакт гэрээ хүчин төгөлдөр болж, АНУ-ын Мянганы Сорилтын корпорацаас олгох санхүүжилтийн эрх нээгдсэн. Ингэснээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх

бэлтгэл ажил бүрэн хангагдаад байна. Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэр ашиглалтад орсноор ус хангамжийн төвлөрсөн системд жилд 50 сая хүртэл м3 ус нийлүүлэх бөгөөд Улаанбаатар хотын баруун хэсэг Туул, Био, Жаргалант тосгон, Сонгинохайрхан дүүргийн Тахилт, Баянголын амын хэрэглэгчдийг болон шинээр байгуулагдах Шинэ зуун мод, Майдар хотуудыг усаар хангах юм. Түүнчлэн хаягдал усыг дахин боловсруулж, эргүүлэн ашиглах төсөл хэрэгжснээр жилдээ 18.0 сая м3 хүртэл хэмжээний усыг дахин боловсруулж, Дулааны 3,4-р станцуудын технологийн хэрэгцээнд нийлүүлнэ. Ингэснээр станцуудын технологийн хэрэгцээнд нийлүүлж байгаа газрын гүний усны эрэлтийг багасгаж, цэнгэг усны нөөцийг хамгаалах ач холбогдолтой.


**Эх сурвалж:Барилга, хот байгуулалтын яам**

## 54 СУМЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, ДОТУУР БАЙРАНД СУУРИЛУУЛАХ "АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ"- ИЙН АЖЛЫН ДААЛГАВРЫГ БОЛОВСРУУЛЛАА

Хот, хөдөөгийн хүүхдийн сурах орчны ялгааг арилгах, тав тухтай орчинд суралцах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд улсын хэмжээнд 819 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжтай болгох юм. Ариун цэврийн байгууламжтай болгох ажлын санхүүжилт болох нийт 100 тэрбум төгрөгийн төсвийг “Эрдэнэт” ТӨҮГ-аас 2021, 2022 онд нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлэж байгаа аж. Харин тендер шалгаруулах үйл ажиллагааны хувьд БШУЯ-ны сонгосон технологийн дагуу явагдах юм байна. 2021 онд 16 аймгийн 101 сумын боловсролын салбарын 450 барилгын ариун цэврийн байгууламж шинэчлэгдэнэ гэсэн төлөвлөгөө бий. Тэгвэл БХБЯ-ны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газраас 16 аймгийн 54 сумын сургууль, цэцэрлэг, дотуур байранд суурилуулах ариун цэврийн байгууламжийн “Ажлын даалгавар”-ыг боловсруулаад байна. Ажлын даалгаврыг тухайн орон нутгийн Засаг даргаар баталгаажуулан, урьдчилсан төсөв боловсруулан Боловсрол шинжлэх ухааны яаманд хүргүүлээд байна.

**Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам**

## ТУУЛ ГОЛД НУТАГШУУЛЖ БУЙ МИНЖ ИХЭРЛЭЖЭЭ



Туул голын экосистемийн доройтлыг багасгаж, голын сав газрын экологийн нөхцөлийг байгалийн аясаар сэргээх цогцолбор арга хэмжээ болох Төв Азийн минжийг үржүүлэх, Туул голд нутагшуулах ажил 2012 оноос эхлэн 9 дэх жилдээ хэрэгжиж буй. Туул голын эх болон Заан, Тэрэлж голуудад нийтдээ 57 бодгаль минжийг нутагшуулж, үр дүнд хяналт тавьж байна. Нийслэлийн Байгаль орчны газрын “Минж үржүүлэх, нутагшуулах төв”-д бойжиж буй нэг бодгаль минжнээс анх удаа 4 ихэр төл авчээ. Энэ нь ховор тохиолдол бөгөөд идэш тэжээл амьдрах орчин нөхцөл тааламжтай байгаагийн үр дүн аж. “Усны инженер” хэмээн нэрлэгддэг минж нь голын усны төвшинг нэмэгдүүлэх замаар амьдарч буй орчныхоо байгалийн тэнцвэрт байдлыг хангадаг билээ.

**Эх сурвалж: gogo.mn**

## ТОВЧХОН

- Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор гэрээр тусгаарлагдаж байгаа иргэдэд УСУГ-аас нэмэлт 5 усны машин гаргаж зөөврийн усаар үйлчилж байна. **Эх сурвалж: Tovch.mn**
- Монгол Улсын зөвлөх инженер Б.Болдбаатар: “...Монгол Улсын нутаг дэвсгэрт арван том голын 33 байршилд усан сан байгуулах боломжтой гэж өмнөх судалгаануудад түшиглэж, мөн шинээр илрүүлж тодорхойлж гаргасан. Усан сангаа ус хангамжийн зориулалтаар ашиглах, эрчим хүч үйлдвэрлэх, газар тариалан усжуулалт, аялал жуулчлал гээд олон зориулалтаар ашиглаж болдог. ...” **Эх сурвалж: Өдрийн сонин (dnn.mn)**

## УСНЫ СЭДЭВТ ЦАХИМ ХУРЛУУД

- Олон улсын усны холбооноос **Дэлхийн Усны Конгрессыг** 2021 оны 5 дугаар сарын 24-нөөс 6 дугаар сарын 4-ний хооронд анх удаа цахимаар зохион байгуулах гэж байна. Хурлаар усны салбарын бүхий л асуудлыг Ус ашиглалтын байгууллагын менежмент, Хаягдал усны боловсруулалт ба нөөцийн сэргээлт, Ундны ус ба дахин боловсруулсан усыг унданд хэрэглэх нь, Усны хангамж, ариутгах татуургын системийн хотын хэмжээний төлөвлөлт, үйл ажиллагаа, Оролцогч талуудын харилцаа, хамтын ажиллагаа ба түншлэл, Усны нөөц ба томоохон хэмжээний усны нөөцийн менежмент гэсэн 6 багцад сэдэвт багтаан хэлэлцэх юм байна. Хуралд **энэ холбоосоор** бүртгүүлэх боломжтой бөгөөд хурлын дэлгэрэнгүй хөтөлбөрийг **эндээс** үзэж танилцах боломжтой. **Эх сурвалж: Олон улсын усны холбоо**
- Хот, суурин газрын усны менежментийн асуудлаарх дэлхийн хамгийн том арга хэмжээнүүдийн нэг болох “Сингапурын Олон улсын усны долоо хоног” 2021 оны 6 дугаар сарын 22-ноос 7 дугаар сарын 2-ны хооронд цахимаар зохион багуулагдана. **Эх сурвалж: SIWW**